



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/02/НА-СТА-ТӨА

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитор В.Цогжаргал Утас: 99158257 Цахим хаяг: Tsojiargalb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	1
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.15 № 143

танай _____-ны № _____-т

“АРХАНГАЙ АЗЗА” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ю.ГАНЗОРИГ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 220 дугаар “Авто замын засвар арчлалтын компаниудыг өөрчлөн зохион байгуулах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу “Архангай АЗЗА” ТӨХК-ийг шинээр байгуулагдах “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-д нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах шийдвэр гарсан байна.

Аудитын гол асуудал

ТӨБЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 577 дугаар тогтоолоор компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай АЗЗА ТӨХК-ийн “Улсын чанартай авто зам, замын байгууламжид 2023 онд арчлалт, засварын ажил гүйцэтгэх”, “Олон улсын, улсын чанартай авто зам, замын байгууламжуудыг хариуцан ажиллах”, “Улсын чанартай авто замд ээлжит засварын ажил гүйцэтгэх” захиалагч гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээний биелэлтийг Зам тээвэр хөгжлийн яамнаас 91.9 хувьтай үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.ХӨРӨНГӨ		
1.1.Эргэлтийн хөрөнгө		
1.1.1.Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,003,130.33	98,857,305.32
1.1.3. Татвар НДШ-ийн авлага	24,782,731.19	8,644,730.33
1.1.6.Бараа материал	566,473,831.34	557,042,713.88
1.1.11. Эргэлтийн хөрөнгийн дүн	599,259,692.86	664,544,749.53
1.2. Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1 Үндсэн хөрөнгө	831,041,444.45	829,754,923.66
1.2.2 Биет бус хөрөнгө	47,341,600.00	47,341,600.00
1.2.12 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	878,383,044.45	877,096,523.66
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,477,642,737.31	1,541,641,273.19
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1 Өр төлбөр		
2.1.1 Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1 Дансны өглөг	53,156,631.27	73,632,798.90
2.1.1.3 Татварын өр	0.00	17,274,991.82
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	840,596.00	0.00
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	53,997,227.27	90,907,790.72
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	198,657,551.00	198,657,551.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	198,657,551.00	198,657,551.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	252,654,778.27	289,565,341.72
2.3 Эздийн өмч	971,338,586.80	971,338,586.80
2.3.1 Төрийн	971,338,586.80	971,338,586.80
2.3.6 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	105,238,307.65	105,238,307.65
2.3.9 Хуримтлагдсан ашиг	148,411,064.59	175,499,037.02
2.3.11 Эздийн өмчийн дүн	1,224,987,959.04	1,252,075,931.47
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,477,642,737.31	1,541,641,273.19

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	1,531,506,413.21	3,111,694,250.92
2.Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,230,990,804.13	2,811,023,962.84
3. Нийт ашиг (алдагдал)	300,515,609.08	300,670,288.08
10. Ерөнхий ба удирдлагын зардал	238,244,269.22	262,632,392.95
12. Бусад зардал	58,881,587.01	7,940,148.00
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,389,752.85	30,097,747.14
19. Орлогын татварын зардал	338,975.29	3,009,774.71
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	3,050,777.56	27,087,972.43
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,050,777.56	27,087,972.43
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	3,050,777.56	27,087,972.43

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	971,338,586.80	105,238,307.65	148,411,064.59	1,224,987,959.04
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			27,087,972.43	27,087,972.43
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдэлийн хэрэгжсэн дүн				
9	2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	971,338,586.80	105,238,307.65	175,499,037.02	1,252,075,931.47

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлтийн нэр	Өмнөх үеийн дүн	Тайлант хугацаа
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,667,104,998.80	3,345,716,696.50
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,970,000.00	0.00
Бусад мөнгөн орлого	1,662,134,998.80	3,345,716,696.50
1.2 Мөнгөн зарлагын дүн	1,922,983,525.41	3,258,834,595.51
Ажиллагчдад төлсөн	384,025,251.00	455,877,656.80
Нийгмийн даатгалын байгуулгад төлсөн	131,074,041.65	150,611,231.93
Бараа материал худалдан авахад төлсөн	870,945,640.45	2,024,101,276.27
Ашиглалтын зардал төлсөн	0.00	2,632,677.74
Татварын байгуулгад төлсөн	123,502,411.71	192,499,910.77
Бусад мөнгөн зарлага	413,436,180.60	433,111,842.00
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	86,882,100.99
Мөнгөн зарлагын дүн	9,700,000.00	0.00
Төлсөн ногдол ашиг	9,700,000.00	0.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0	86,882,100.99
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	273,581,656.94	8,003,130.33
Мөнгө, ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,003,130.33	98,857,305.32

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

	х/нэгж	2023 оны
--	--------	----------

“Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		2022 оны гүйцэтгэл	төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт				
	а/Гол нэр төрлөөр	биет	318.0	318.0	318.00
2	Нийт орлого	м.төг	1,531,506.4	1,469,521.9	3,111,694.2
Үүнээс	а/Улсын чанартай зам засвар арчлалтын ажил	м.төг	1,510,552.8	1,289,521.9	3,111,694.2
	б/Орон нутгийн чанартай зам гүүрний ажил	м.төг	-	120,000.0	-
	в/Бусад	м.төг	20,953.6	60,000.0	-
3	Нийт зардал	м.төг	1,528,110.9	1,440,131.5	3,081,596.5
	Үүнээс удирдлагын зардал	м.төг	238,244.2	242,786.3	262,632.3
4	Татварын өмнөх ашиг	м.төг	3,395.3	29,390.4	30,097.7
5	Цэвэр ашиг/алдагдал/	м.төг	3,055.8	26,451.4	27,087.9
6	Төсвийн нийт төлбөр	м.төг	250,122.8	253,515.0	524,340.6
6.1	а/Орлогын татвар	м.төг	339.5	2,939.0	3,009.7
6.2	б/НӨАТ	м.төг	76,976.0	76,815.9	305,599.7
6.3	в/НДШ	м.төг	131,074.0	131,864.9	150,611.2
6.4	г/ ХХОАТ	м.төг	38,510.3	39,108.7	32,590.8
6.5	д/ ҮХЭХАТ	м.төг	1,306.8	1,306.8	1,306.8
6.6	е/Гаалийн татвар	м.төг	-		
6.7	ё/Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	1,163.2	1,389.3	1,389.3
6.8	ж/Бусад татвар	м.төг	753.0	90.4	29,833.1
7	Төрийн өмчийн ноогдол ашиг	м.төг	9,700.0	6,493.1	-
8	Нийт ажиллагсдын тоо	м.төг	37	37	37
9	Нийт цалингийн сан	м.төг	515,773.1	539,534.0	580,126.8
10	Нэг ажилтны дундаж цалин	м.төг	1,109.5	1,251.1	1,306.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	төг	0.99	0.98	0.99
12	Хөрөнгө оруулалт	м.төг	10,000.0	75,000.0	74,500.0
13	Нийт авлага	м.төг	24,782.1	10,345.5	8,644.7
	Үүнээс: найдваргүй	м.төг	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	252,654.7	200,111.9	289,565.2
	Үүнээс:богино хугацаат өр төлбөр	м.төг	53,997.2	1,454.4	90,907.7
	Урт хугацаат өр төлбөр		198,657.5	198,657.5	198,657.5

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй бөгөөд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой дараах 3 асуудалд зөвлөмж хүргүүлээ.

3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: / Байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгын зарим маягыг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврын дагуу бэлтгээгүй орхигдуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааврыг мөрдөж иж бүрэн тайлан гаргаж хэвших

2. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: / Тайлант хугацаанд дансны өглөг 20,476.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 73,632.8 мянган төгрөгийн өр төлбөрийн тооцоотой байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Богино хугацаат өр төлбөрийг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах*

3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: / Тайлант онд нийт 157 мэдээллийг шилэн дансны цахим хуудаст байршуулахаас 152 мэдээллийг хугацаанд нь 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 7 дугаар зүйлийн 7.1.1-т “... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан шилэн дансны мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх үүргийг хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Шилэн дансны мэдээллийг цахим хуудаст хугацаанд нь мэдээлж хэвших*

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дугаарын 20-ны дотор ирүүлнэ үү.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

“Архангай АЗЗА” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр төлбөрийг барагдуулаагүй	1	0.0					1	0.0				
Санхүүгийн тайлангийн зарим маягтыг журмын дагуу бэлтгээгүй	1	0.0					1	0.0				
Дүн	2	0.0					2	0.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан	1	0.0							1		0.0	
Дүн	1	0.0							1		0.0	

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.